



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 11/148

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 15 дугаар сургуулийн
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу “Өвсний үндэс хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжаар танай сургуулийн барилгад хийгдсэн засварын гүйцэтгэлийн дүн 189,729,205 (нэг зуун наян есөн сая долоон зуун хорин есөн мянга хоёр зуун тав) төгрөгөөр барилгын үнийг нэмэгдүүлэн бүртгэн авахыг Хан-Уул дүүргийн 15 дугаар сургууль (Ө.Шүрэнцэцэг)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 15 дугаар сургууль (Ө.Шүрэнцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА




М.БАЯРАА

Тушаал-2021

115050000437

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын
 даргын 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн
 07/08 дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Хан-Уул дүүргийн 15 дугаар сурууль

№	Эд хөрөнгийн нэр	Үзүүлэлт	Үйлдвэр рлэсэн он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	эх үүсвэр
1	Барилгын гадна засвар	Засварын ажил	2020	шинэ	-	-	-	189,729,205	"Өвсний үндэс хөтөлбөр"	Буцалтгүй тусламж
Барилгын үнийг нэмэгдүүлэн бүртгэх дүн								189,729,205		